УРИАЛГА

2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр

ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ЭРХЭМ ШҮҮГЧИД ЭЭ

Шүүгчийн ёс зүйн стандартын төслийг хэлэлцэн боловсронгуй болгох ажилд Та бүхнийг идэвхтэй оролцохыг уриалж байна. Шүүхэд итгэх олон нийтийн итгэл нь шүүгч бүрийн хараат бус, төвийг сахисан үйл ажиллагаа, хууль ёсны ба үндэслэл бүхий шийдвэр, хүний эрхэм чанарыг хүндэтгэсэн харилцаа, өдөр тутмын ёс зүйтэй зан үйлээр бэхэждэг билээ.

Нийт шүүгчийн III чуулганаас гаргасан зөвлөмжийн дагуу байгуулагдсан Ажлын хэсэг 19 бүлэг, 69 зүйл бүхий Шүүгчийн ёс зүйн стандартын төсөл, түүний үзэл баримтлалыг боловсруулж, нийт шүүгч нартаа танилцуулж, санал авахаар хүргүүлж байна.

Шүүгчийн ёс зүйн стандарт нь сахилгын шинэ зөрчил бий болгохгүй бөгөөд түүний шаардлагад нийцээгүй зан үйл дангаараа сахилгын шийтгэл хүлээлгэх шинэ үндэслэл болохгүй. Сахилгын хариуцлагыг зөвхөн хуульд заасан үндэслэл, журмаар шийдвэрлэнэ. Харин энэхүү стандарт нь ёс зүйн эрсдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эргэлзээтэй нөхцөлд зөв сонголт хийх, өөрийн зан үйлийг эргэцүүлэн үнэлэх, зөвлөгөө авч суралцах, ёс зүйгээ тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн мэргэжлийн хөтөч байх юм.

Төсөлд Банголорын зарчмын хараат бус, төвийг сахисан, шударга, зохистой байдал ба тэгш хандлага, мэргэжлийн ур чадвар, хичээл зүтгэлийн үнэт зүйлсийг тусгасан болно. Эдгээрийг ашиг сонирхлын зөрчил, зүй бус нөлөөлөл, мэдээллийн нууцлал, цахим орчин, хиймэл оюун ухааны хэрэглээ зэрэг бодит нөхцөлтэй холбож, өөрийгөө үнэлэх асуулт, практик жишээ, зөвлөгөө, сургалтаар дамжуулан хүргэхийг зорьж байна.

Шүүгчийн хараат бус байдал нь иргэн бүрийн шударга шүүхээр шүүлгэх эрхийн баталгаа юм. Энэ баталгааг өдөр тутмын үйл ажиллагаандаа бодитоор хэрэгжүүлэхэд хууль зүйн мэдлэгийн зэрэгцээ ёс зүйн зөв сонголт хийх чадвар шаардлагатай. Тиймээс Ёс зүйн стандарт нь шүүгч бидний өргөсөн тангараг, мэргэжлийн үнэт зүйлсийг бодит нөхцөлд хэрхэн хэрэгжүүлэх талаар нийтлэг чиг баримжаа өгөх учиртай.

Ёс зүйн шаардлагыг хэрэгжүүлэхэд шүүгчийг дэмжсэн хамт олны орчин мөн чухал. Шүүгчийн хараат бус байдал, мэргэжлийн байр суурийг хүндэтгэх, зүй бус нөлөөллийг үл тэвчих, түүнийг мэдээлсэн шүүгчийг дарамт, гадуурхалтаас хамгаалах, зөв зан үйлийг үлгэрлэн дэмжих соёлыг төлөвшүүлэх замаар хамтын хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай. Ёс зүйн эргэлзээтэй асуудлыг нээлттэй хэлэлцэж, харилцан суралцах нь хувь шүүгчийн хөгжлийг шүүхийн нийтлэг соёлтой холбох ач холбогдолтой гэж үзэж байна.

Иймд Ёс зүйн стандартын төслийг Монголын Шүүгчдийн холбооны салбар хороо бүр хамтын зарчмаар хэлэлцэж, шүүгч бүр өөрийн болон хамт олны туршлагад

тулгуурлан дараах асуудлаар саналаа нэгтгэж, 2026 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс өмнө Монголын Шүүгчдийн холбоогоор дамжуулан Ажлын хэсэгт ирүүлнэ үү:

1. Заалтын утга, нэр томьёо ойлгомжтой, хоорондоо уялдаатай эсэх; нэмэх, өөрчлөх, хасах шаардлагатай томьёолол, түүний үндэслэл;

2. Өдөр тутмын ажил, хувийн амьдрал, цахим орчинд тулгардаг ёс зүйн эргэлзээ, эрсдэлийг төсөл хангалттай хамарсан эсэх; нууцлалыг хадгалсан бодит жишээ, шийдлийн санал;

3. Өөрийгөө үнэлэх асуулт, ёс зүйн зөвлөгөө, сургалт, хамт олны дэмжлэгийг практикт үр дүнтэй хэрэгжүүлэх арга зам.

Таны санал бүр төслийг бодит хэрэгцээнд нийцүүлж, шүүгч бүрд ойлгомжтой, хэрэглэхүйц болгоход үнэтэй хувь нэмэр болно гэдэгт итгэж байна.

Ажлын хэсэг шүүгчдийнхээ хамтын оролцоонд тулгуурлан төслийг боловсронгуй болгож, 2027 оны Нийт шүүгчийн IV чуулганаар батлуулахыг зорьж байна.

Шүүгч та бид мэргэжлийн нийтлэг зарчим, үнэт зүйлсээ өөрсдөө тодорхойлж, түүнийг хувийн зан чанар болгон төлөвшүүлж, өдөр тутам дагаж мөрдсөнөөр аливаа ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэхээс гадна шүүгчийн ажил амьдралаа илүү сайн сайхан, аз жаргалтайгаар мэдэрч, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэхэд тусалж чадна.

АЖЛЫН ХЭСЭГ